

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ХЭРЭГЛЭЭГ
МЕДИА МОНИТОРИНГИЙН СИСТЕМЭЭР ШИНЖЛЭХ НЬ

Э.Мөнх-Учрал

Хураангуй: Орчин үед хэл, бичгийн хэрэглээ, хандлага, хувьсал өөрчлөлтийг хэл шинжлэл, цахим хэл шинжлэл, хиймэл оюун, нийгэм, социологи, маркетинг, хууль эрх зүй гээд маш олон талаас нь судалж байна. Ийн судлахад, сүүлийн үед янз бүрийн их хэмжээний өгөгдөл (big data), түүнд тулгуурласан судалгааг чухалчилж байгаагийн дотор *цахим орчны өгөгдлийн шинжилгээ* (social data analysis) чухал байр суурь эзлэх болжээ. Тиймээс, энэхүү өгүүлэлд цахим орчноос монгол хэл, бичгийн өгөгдөл цуглуулахад медиа мониторингийн систем ашиглах боломжийг анхлан туршлаа. Кудос систем ашиглан Монголын бүх мэдээний сайт, бүх Жиргээний хаяг, Нүүр номын 10,000 гаруй нээлттэй тохиргоотой бүлгүүд, эдгээр эх сурвалж бүрд хамаарах олон сэтгэгдлээс 2020 оны 8.1-2020.11.1 хүртэлх 3 сарын хугацаанд нийтлэгдсэн, *монгол* гэсэн түлхүүр үг агуулсан **136,682** мэдээ, мэдээллээс **11,855,350** нэгж бүхий бодит, боловсруулаагүй өгөгдлийг бодит хугацаанд цуглуулсан. Эндээс өгөгдлийн боловсруулалт хийж **81,756** үгийн язгуур үндэс болон нөхцөлөөр хувилсан үгсийг гарган авлаа. Тус судалгаагаар, гадаад үгийн хэрэглээ толь бичигт орсноос 4-5 дахин их, алдаатай бичих нь зөв бичихээсээ бараг 50%-аар их байгааг харуулах болно.

Түлхүүр үг: *их хэмжээний өгөгдөл (big data), нийгмийн сүлжээ (social networks), мэдээний сайт (news web site) Нүүр ном (Facebook), Жиргээ (Twitter), медиа мониторинг (media monitoring), боловсруулаагүй өгөгдөл (raw data/primary data), монгол хэл, бичгийн хэрэглээ (usage of Mongolian language)*

Удиртгал

Дэлхий дахинаа *өгөгдөл (data)* хамгийн чухал судлагдахуун болж, ирээдүйд өрсөлдөөнийг тодорхойлох хүчин зүйл нь медиа, био, хэлний, бичгийн, бүртгэлийн гэх мэт янз бүрийн их хэмжээний өгөгдөл (big data) болох нь хэдийн дамжиггүй болсон билээ. Учир нь, хаана их хэмжээний өгөгдөл байна, тэндээс бодит судалгаа, бодит хэрэглээ, бүтээгдэхүүн, хяналт, аюулгүй байдал гээд орчин үеийн амьдралын бүхий л хүрээнд нэвтрэх хүч, боломж бий болдог тул аль ч төрлийн өгөгдлийг асар их зардал, цаг хугацаа, хүч хөдөлмөр зарж цуглуулж, боловсруулалт хийдэг. Өгөгдлийг нэг талаас, программчлалд зориулсан хэлний мэдлэгт суурилан, төрөл бүрийн технологи, программ бүтээж хэрэглээнд нэвтрүүлэх *хэл бичгийн боловсруулалт (Natural Language Processing)*, нөгөө талаас, хүнд зориулсан хэлний мэдлэг бүтээх орчин үеийн хэл шинжлэлийн салбаруудад үр дүнтэйгээр ашиглаж байна.

Сүүлийн үед, өгөгдлийн маш том хэсэг нь цахим орчинд, тэр дундаа, мэдээ мэдээллийн сайтууд, Нүүр ном (Facebook), Жиргээ (Twitter) зэрэг нийгмийн сүлжээнд эргэлдэж байгааг *цахим орчны өгөгдөл (social data)* хэмээн онцгойлон судалж байна. Тийм ч учраас, олон хэл, бичгийн орчин цагийн бодит хэрэглээ, цахим орчин хэлэнд хэрхэн нөлөөлж буй талаарх

төрөл бүрийн судалгааг цахим орчин, түүний хэрэглэгчдэд тулгуурлан хийх болжээ (Crystal 2011; Daniel Cunliffe 2013; Stjhr 2014; Lysbeth Jongbloed-Faber et al. 2015; Atef Abusa'aleek 2015; Anastasia Zhuravleva 2016; Amaz Herdagdelen, Marco Marelli 2017; Annika Lantz-Andersson 2017; Milana Abbasova 2019; Huda 2020). Англи хэлээр жишээлбэл, 2010 оны 12 сараас 2011 оны 7 сар хүртэлх 75 сая англи хэлээрх жиргээ, 2014 оны 11 сараас 2015 оны 1 сар хүртэлх нийтийн тохиргоотой Нүүрномын америк англи хэлээрх 1,10 тэрбум токен, бритиш англи хэлээрх 1,18 тэрбум токен бүхий өгөгдөл цуглуулан судалжээ (Amaz Herdagdelen, Marco Marelli 2017: 978).

Монголд, энэ чиглэл харьцангуй шинэ бөгөөд ерөнхий ойлголт өгөх (Г.Гэрэлмаа 2012; Б.Энхмаа 2015; Д.Боролзой 2019; Э.Равдан 2020), өгөгдөлд буюу цахим орчинд тулгуурлан судлах (Ү.Хүрэлбаатар 2013, Д.Боролзой 2019) зэргийг агуулж байна. Түүнчлэн, орчин цагт түгээмэл тулгарч байгаа хэл найруулга, зөв бичих дүрэм, гадаад үгийн хэрэглээ гэх мэт асуудлыг түгээмэл тохиолдлын жишээнд суурилсан маш олон бүтээл гарсан билээ (Э.Пүрэвжав 1996, 2005; Ш.Чоймаа 2009, Ц.Шагдарсүрэн 2007, О.Самбуудорж 2013, О.Шинэбаяр нар 2015 гэх мэт).

Монголд судалгаанд дурдаж буй өгөгдлийн сангийн хувьд цахим өгөгдлийн сан, цахим орчны өгөгдлийн сан хоёрыг ялгаатай авч үзэх нь зүйтэй.

Цахим өгөгдлийн сан, түүний судалгаанд, уран зохиол, сонин нийтлэл, хуулийн эхээс бүрдүүлсэн 170,000 толгой үг буюу нийт 5 сая орчим үгтэй, МУИС-ийн Компьютер хэл шинжлэлийн төвийн сан (М.Энхжаргал 2010; Ч.Алтангэрэл, М.Энхжаргал 2013); Болорсофтын англи, монгол, япон, герман, солонгос таван хэлний орчуулгын сан (bolor-toli.com), хэл боловсруулалтын сан (bolor-toli.com); Монгол уран зохиолын 108 ботиос бүрдүүлсэн 255,617 толгой үг буюу 7,880,161 үг бүхий хөмрөг (Т.Пүрэвсүрэн, Д.Боролзой 2008; Пүрэвсүрэн 2016); толь бичиг, сурвалж бичгээс бүрдүүлсэн 55,000 гаруй толгой үгтэй хэл зүйн хөмрөг болон 30,000 орчим оноосон болон товчилсон нэрийн дэд хөмрөг (Э.Мөнх-Учрал 2005, 2010), *Монгол хэлний их тайлбар толь* (mongoltoli.mn) зэргийг ашиглаж ашиглан монгол хэлийг судлах Э.Мөнх-Учрал (2005, 2010), М.Энхжаргал (2010, 2019), Ж.Ганбаатар (2016), Н.Оюундарь (2016), Т.Пүрэвсүрэн 2016, 2019) нарын судалгааг дурдаж болох юм. Эдгээр нь бүгд толь бичиг, уран зохиол, сонины буюу бичгийн хэлний хөмрөгт суурилсан өгөгдөл болно.

Цахим орчны өгөгдөл (social data) ашигласан судалгааг авч үзвэл, Б.Цэнгэлмаа өдөр тутмын ярианы 65,478 үг (2018:2); Д.Мөнхчимэг, Ц.Чимэддондог нар 43 хэвлэл мэдээллийн сайтын хүрээнд үзэн ядах үг хэллэгтэй 50 мэдээ, нийтлэл (2018:66); Д.Боролзой нийгмийн сүлжээний сайтууд, мэдээллийн веб хуудас, гар утасны мессеж (2019:10-11), Б.Энхмаа 64 хүний нэг жилийн хугацаанд *Нүүр номоор* харилцсан материалыг (2019:172) тус тус ашиглажээ.

Дээр өгүүлснээс харвал, нэг талаас, цахим орчны өгөгдлийг тодорхой тооны мэдээний сайтаар төлөөлүүлэх, нийгмийн сүлжээнд буй жишээ баримтыг түүвэрлэх, Гүүгл зэрэг хайлтын системээр тодорхой түлхүүр үгээр хайлт хийх замаар судалж байна. Нөгөө талаас, цахим орчин дахь өгөгдлийн эх сурвалж нь голчлон сонин хэвлэлийн цахим, хувилбар байгаа учир нийгмийн сүлжээний бодит боловсруулаагүй өгөгдөл (raw data/ primary data) бус байна. Гуравд, цахим орчны өгөгдлийн сангийн хамрах хүрээ нь бодит хэрэглээтэй харьцуулахад өргөн бус байна.

Судалгааны зорилго

Орчин үеийн монгол хэл, бичгийн хэрэглээнд тулгарч буй хэл найруулгын алдаа, үгийн баялаг муу, зөв бичих дүрмийн алдаа, харь үгийн хэрэглээ, гадаад хэлний орчуулгын нөлөө зэрэг нь судлаачдын төдийгүй олон нийтийн анхаарлыг татсан сэдвийн нэг болж, монгол

хэл мөхөх эсэх талаар ч хэлэлцэж буй. Эрдэмтэн судлаачид монгол хэл мөхөхгүй гэдэг байр суурийг ЮНЕСКО-ийн баримталдаг хэл шинжлэлийн шалгуур үзүүлэлт, ЮНЕСКО-оос монгол хэлийг аюулд орсон, мөхөхөд хүрсэн хэл хэмээн зарлаагүй хэмээх баримт болон өөрсдийн үзэл бодолд түшиглэн илэрхийлж байгаа (Өнөрбаян, 2013, 2020, Гэрэлмаа, 2015: 15-20, Баттогтох, 2020 г.м). Энэ асуудалд холбогдох томхон судалгаа болох Компьютер хэл шинжлэлийн төвийн 5 сая үгтэй санд 166,000 толгой үг байгаагаас, 129,000 нь алдаагүй үг, 38,000 нь алдаатай буюу нийт үгийн 20% алдаатай байна хэмээжээ (М. Энхжаргал 2010: 43-44). Гэвч энэ нь, цаг хугацааны хувьд XX эхнээс XXI зууны эхэн үеийг хамарсан, уран зохиол, хууль, сонин нийтлэлийн эхээс буюу харьцангуй хяналттай бичгийн хэлний өгөгдлийн судалгаа учир, одоог хүртэл орчин цагийн монголчууд өдөр тутамдаа хэдэн үг хэрэглэж байгаа, түүнд гадаад үгийн эзлэх хувь, зөв бичих дүрмийн алдаа хэр зэрэг газар авсан зэрэг нийгэмд хэдий тодорхой болсон боловч тоо баримт бүхий тодорхой судалгаагаар дутагдаж байна гэж хэлж болно. Үүнд, цахим орчны өгөгдлийн хязгаарлагдмал байдал, боловсруулаагүй өгөгдлийг боловсруулах амаргүй ажилтай шууд уялдаатай гэж үзэж байна.

Иймээс, цахим орчны өргөн хүрээтэй, тодорхой хугацаанд хамаарах их хэмжээний өгөгдөл цуглуулж, олборлосон өгөгдөлд боловсруулалт хийх замаар монгол хэл, бичгийн бодит байдлыг өгөгдлийн анхдагч задлан шинжилгээгээр дурдсан асуудлуудад ямар нэг хэмжээгээр хариулахыг хичээлээ.

Судалгааны арга

Энэхүү судалгааг цахим орчны өгөгдлийн задлан шинжилгээ (social data analysis)-ээр хийлээ.

Эхний шатанд, *өгөгдлийн шаардлага* (data requirement)-ыг цахим орчны хамгийн идэвхтэй бичвэрийн мэдээллийн хэсэг болох мэдээний сайт (news websites), Нүүр ном (Facebook), Жиргээ (Twitter)-т *бодит хугацаа* (real time)-нд урсаж байгаа мэдээлэл байх, боломжит их хэмжээний өгөгдөл байх, боловсруулаагүй өгөгдөл байх хэмээн тодорхойлов. Монголд 100 орчим мэдээний сайт байдаг бол (Монголын хэвлэлийн хүрээлэн 2013: 1), 2019 оны байдлаар Нүүр ном хэрэглэгч 2,2 сая, Жиргээ хэрэглэгч 40,000 (Зиндаа.мн) байна. Нэмж хэлэхэд, мэдээний сайт нь монгол хэлний хэм хэмжээг баримтлах талаар харьцангуй хяналттай байдаг бол Нүүр ном, Жиргээнд энэ талаар төдийлөн хайхардаггүй, тухайн үеийн байдлаар хандах, хянаж нягтлахгүй байх нь олонтоо.

Хоёрт, цахим орчинд түгж буй шаардлагад нийцсэн *өгөгдлийг цуглуулах* (obtaining social data) шатанд монгол хэлээр кирилл бичиг болон латин үсгээр бичсэн мэдээ, мэдээлэлд медиа мониторинг хийдэг “Кудос” системийг ашиглалаа.

Гуравд, *өгөгдлийн боловсруулалт* (data processing)-ын шатанд цуглуулсан өгөгдлийн ангилан ялгав. Ямар нэгэн алдаагүй үгсийг ялгахдаа “Болор дуран” алдаа шалгах программ хэрэглэв.

Дөрөвд, *өгөгдөл цэвэрлэх* (data cleaning) шатанд алдаатай үгийн зөв бичлэгийг оноож хадлаа.

Эцэст нь, *өгөгдлийн задлан шинжилгээ* (data analysis) хийлээ.

Ер нь, өгөгдөл цуглуулах, боловсруулах, цэвэрлэх, задлан шинжлэхэд маш их цаг, хөдөлмөр зардаг. Компьютер хэл шинжлэлийн төвийн 5 сая үгтэй хэлний хэм хэмжээний талаар харьцангуй хяналттай бичигдсэн, бичгийн хэлний өгөгдлийн сангаар жишээлэхэд, эх сонгох, хайх, txt хэлбэрт буулгах, цэвэрлэх, загварчлахад таван судлаач 3 сар хийж дуусаагүй, нийтдээ 1 жилийн хугацаа зарцуулсан байдаг (М. Энхжаргал 2010: 43-44). Цахим орчны нийгмийн сүлжээний өгөгдөл нэлээд ажиллагаа ихтэй, цаг хугацаа шаардсан болохыг тэмдэглэе.

Судалгааны хэрэглэгдэхүүн

“Кудос систем” бол хэрэглээнд буй цахим орчны хүрээнд одоогоор хамгийн өргөн хүрээтэй ажилладаг, хиймэл оюуны медиа мониторингийн программ юм.

Судалгааны хэрэглэгдэхүүний хамрах эх сурвалж:

- Монголын бүх мэдээний сайт буюу 100 гаруй *сайт* (web sites),
- 10000 гаруй *Нүүр ном* (facebook)-ын *нээлттэй тохиргоо бүхий хуудас* (public pages), бүлэг (groups),
- *Жиргээ* (Twitter)-ний бүх *хаяг* (accounts)
- Дээр дурдсан бүр эх сурвалж дээр бичсэн бүх *сэтгэгдэл* (comments)-ийг хамардаг.

Судалгааны хэрэглэгдэхүүний хамрах хугацаа:

Хамгийн сүүлийн үеийн цахим орчин дахь монгол хэл, бичгийн хэрэглээг судлах зорилгоор 2020 оны 8.1-2020.11.1 хүртэл 3 сарын хугацааг сонгосон.

Хайлтын хугацаа: Бодит хугацааны хайлт (real time search)

Судалгааны хэрэглэгдэхүүнд ашигласан түлхүүр үг:

Тус хугацаанд хамаарах хамгийн олон боломжит мэдээг олборлох зорилгоор, түгээмэл хэрэглэгддэг “монгол” гэсэн түлхүүр үгийг сонголоо.

Судалгааны хэрэглэгдэхүүний хэмжээ:

Дурдсан цахим орчны эх сурвалжийн хүрээнд 3 сарын хугацаагаар зааглан *монгол* гэсэн түлхүүр үгээр өгөгдөл олборлоход хайлтын дүнд, нийт **136,682 мэдээ, мэдээлэл** олдсон бөгөөд үүнд давтагдсан тоогоор **11,855,350** үг байна. 2020 оны 8.1-2020.11.1

Өгөгдлийн боловсруулалт, анхдагч задлан шинжилгээ

Боловсруулаагүй өгөгдөлд хэл шинжлэлийн *хэлзүйн хувиллаар хувилсан үгсээс* гадна хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн үг нийлүүлсэн, үг тасарсан, дан үсэг, хаалт хашилт гэх мэт тэмдгийн араас тэмдэгтээр заагласан залгавар нөхцөл гэх мэт янз бүрийн мэдээлэл агуулагдаж байна. Тиймээс, хэлзүйжсэн үг, толгой үг, үгийн үндэс гэсэн тогтсон ойлголтын зэрэгцээ, “хоосон зай” (space)-аар тусгаарлагдсан бүхнийг **нэг нэгж** хэмээн нэрлэлээ. Нэгж нь ихэнх тохиолдолд хэлзүйжсэн үгтэй дүйнэ.

- “Кудос”-ын хайлтын дүнд олдсон *боловсруулаагүй өгөгдөл* нь 11,855,350 нэгжтэй байна. Энэ нь, орчин цагт монголчууд цахим орчинд 3 сарын хугацаанд мөн тооны бичмэл нэгжээр харилцаж байна гэсэн үг юм.
- Цахим орчноос цуглуулсан 12 сая орчим нэгжийг (үгийн үндэс болон нөхцөлөөр хувилсан хэлбэрийг хамарсан) дараах үндсэн хэсэгт ангилж болохоор байна. Үүнд (*Хавсралт 1-ээс дэлгэрүүлэн үзнэ үү*),

Хүснэгт 1.


Дд	Ангилал	Давтамжийг хассан тоо	Давтамж бүхий тоо
1.	Монгол үг		
	1. Ерийн үг	50610	11,09,168
	2. Этгээд, шинэ үг	255	757
	3. Үг давтах аргаар бүтсэн үг	155	416
	4. Монгол бичгийн кирилл галиг	79	241
	5. Товчилсон үг	2,094	146,297
	6. Аялга үг	68	350

2.	Монгол оноосон нэр		
	1. Монгол хүний нэр	6499	144,803
	2. Газар ус, улс үндэстэн, байгууллагын нэр	2040	59,223
3.	Гадаад үг	19956	238,537
4.	Тодорхойгүй	1462	174,558
	Бүгд	83,218	11,855,350

Тайлбар: Тодорхойгүй гэсэн хэсэгт тасархай нөхцөл, дан үсэг, утга нь ойлгох аргагүй бичсэн үгс зэрэг багтана.

- **Монгол үг, оноосон нэр, гадаад үгийн эзлэх хувь.** Өгөгдлийн давтагдаагүй тоогоорх 83,218 үндсээс тодорхойгүй хэсгийн 1462 нэгжийг хасаад, цахим орчинд хэрэглэж буй **81,756** үгсийг эзлэх хувийг харьцуулан үзүүлбэл,


График 1.



Эдгээр гадаад үгийн дотор оноосон нэр нэлээд хувийг эзэлнэ. Ойролцоогоор 5000 орчим гадаад үг (толгой үг) ашиглаж байх магадлалтай байна. Харьцуулахад, Монгол хэлэнд орсон гадаад үгийн толь бичгүүдэд ойролцоогоор 600-1000 орчим үгийг оруулсан байдаг (Монгол хэлний журамласан толь, Балжинням). Энэ талаар, цаашид нарийвчлан судалбал зохино.

- **Алдаа.** Түгээмэл алдааны нэг хувилбар нь цахим орчинд үгсийг нийлүүлж бичсэнээс үүдэлтэй байна. Нөгөө талаас дүрмийн хувьд алдаатай бичлэгийн тохиолдол үгийн үндсийг гэхээсээ нөхцөлөөр хувилган бичихтэй холбоотой байна. Эдгээрийг харьцуулан харуулбал,

График 2.



Дд		Давтагдаагүй тоо	Давтамжит тоо
1	Зөв бичлэг	17464	10630434
2	Алдаатай бичлэг	33146	459734
3	Нийлүүлсэн алдаа	5418	183183

Алдаатай бичлэгийн хувьд дүрмээ мэдэхгүй, буруу товч дарсан, үгийг цахим орчинд түгээхийн тулд зориудаар нийлүүлж бичсэн, санамсаргүй нийлүүлж бичсэн зэрэг шалтгаантай болох нь судалгааны явцад ажиглагдаж байв. Жишээ нь, бидний сонгосон “монгол” хэмээх үгийн орчинд үзвэл, алдаатай бичсэн 49, нийлүүлж бичсэн 96, бүгд 145 алдаатай бичлэг байгаа ба тус бүрийнх нь давтамжийг нэмж тооцвол, нийт 6927 удаа алдаатай бичигджээ. Дэлгэрэнгүйг *Хавсралт 2-оос үзнэ үү*. Энэ талаар, цаашид нягтлан судалбал зохино.

- **Давтамж.** Орчин цагийн монгол хэлэнд хэрэглэж байгаа үгсийн давтамжид тоо болон үгээр ажиглалт хийлээ. Жишээг *Хавсралт 3-аас үзнэ үү*.

График 3.




График 4.



Дүгнэлт

Энэхүү судалгааг цахим орчинд түгээмэл тохиолдож байгаа гэж үзсэн жишээгээрээ хайлт хийх замаар бус, цахим орчин дахь монгол хэл, бичгийн бодит хэрэглээг хиймэл оюуны медиа мониторингийн систем ашиглан судлах анхны оролдлогыг хийлээ. *Кудос системээр* Монголын бүх мэдээний сайт, бүх Жиргээний хаяг, Нүүр номын 10,000 гаруй нээлттэй тохиргоотой бүлгүүд, эдгээр эх сурвалж бүрд хамаарах олон сэтгэгдлээс 2020 оны 8.1-2020.11.1 хүртэлх 3 сарын хугацаанд нийтлэгдсэн, *монгол* гэсэн түлхүүр үг агуулсан **136,682** мэдээ, мэдээллээс **11,855,350** нэгж бүхий бодит, боловсруулаагүй өгөгдлийг бодит хугацаанд цуглуулан, боловсруулж, одоогоор хамгийн өргөн хүрээнд судлахыг хичээв. Өөрөөр хэлбэл, энэ нь цахим орчинд мэдээлэл бичиж, түгээж байгаа сургуулийн хүүхдээс ахмад настан хүртэл бүх насны, эрэгтэй эмэгтэй, боловсрол мэдлэгийн түвшин, ажил мэргэжил, хөдөө орон нутаг, нийслэл, Монголд болон гадаадад оршин сууж байгаа гээд ерөөс монгол хэл хэрэглэж байгаа бүхий л түвшнийг хамарсан гэж хэлж болох юм.

Судалгааны дүнд, 12 сая орчим нэгжийг боловсруулж, давтагдаагүй тоогоор 83,218 нэгж гарснаас, тасарсан, утга тодорхойгүй хэсгийг хасаж **81,756** үгийн язгуур үндэс болон нөхцөлөөр хувилсан үгсийг гарган авлаа.

Компьютер хэл шинжлэлийн төвийн 5 сая үгтэй бичгийн хэлний өгөгдлийн санд 166,000 толгой үг байгаагаас, 129,000 нь алдаагүй үг, 38,000 нь алдаатай буюу нийт үгийн 20% алдаатай гэсэн 11 жилийн өмнөх судалгаатай (М. Энхжаргал 2010: 43-44) харьцуулахад, цахим орчны бодит хэрэглээний өгөгдөлд, монгол үг 66%, гадаад үг 24%, оноосон нэр 10%-ийг тус тус эзлэх ба зөв бичлэг 17464, алдаатай бичлэг 33,146 буюу алдаатай бичлэг нь зөвөөсөө бараг 2 дахин их гэсэн цочирдом тоон үзүүлэлт гарч байна. Энэ нь дүрмийн, шивэх алдаа, зориудаар нийлүүлж бичих алдаа гэх мэт олон шалтгаантай аж.

Нэгтгэн дүгнэвэл, нэгд, орчин цагийн монгол хэл шинжлэлд, дэлхийн бусад хэлний адилаар төрөл бүрийн их хэмжээний өгөгдөлд суурилсан судалгаа хийхэд анхаарал хандуулбал зохилтой байна. Хоёрт, богино хугацаанд их хэмжээний өгөгдөлд цуглуулах

одоогоор хамгийн үр дүнтэй аргын нэг нь медиа мониторингийн систем байж болохоор байна. Ийм аргаар монгол хэлний хэрэглээг хугацааны илүү өргөн хүрээнд, тасралтгүй шинжлэх нь чухал юм. Цаашид алдааны шалтгаан, гадаад үгийн эзлэх хувийн жин, идэвхтэй хэрэглэж байгаа толгой үгийг тооцоолох зэргээр нягтлах шаардлагатай. Гуравд, цахим орчинд монгол хэлний бодит хэрэглээний байдал үнэхээр сэтгэл эмзэглүүлэх түвшинд хүрснийг тоо баримт нотолж байна. Тиймээс, монгол хэл, бичгийн боловсролыг бүх шатанд онцгой анхаарах шаардлага хэдийн тулгарчээ.

Ном зүй

- Алтангэрэл Ч., Энхжаргал М.** 2013. *Монгол хэлний үг, үе, үсгийн давтамжийн судалгаанд суурилан компьютерын гарын жишиг байрлалыг зохиосон нь*. Цахим засаглал, мэдээллийн технологи. 30-34.
- Балжинням Н.** 2008. *Монгол хэлний гадаад үгийн толь*. Уб., МУИС-ийн Хэвлэх үйлдвэр.
- Баттогтох Г.** 2020. *Монгол хэл мөхөх аюулд ороогүй*. <https://montsame.mn/mn/read/223766>
- Боролзой Д.** 2019. *Цахим орчин дахь монгол хэлний хэм хэмжээ*. Хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. F0232201.
- Боролзой Д., Энхжаргал М.** 2017. *1987 оны Үнэн сонин болон 2017 оны Өдрийн сонины үсгийн давтамжийг харьцуулах нь*. Хэрэглээний хэл шинжлэл II.
- Ганбаатар Ж.** 2016. *Орчин цагийн Монгол хэлний үг бүтээх дагаврын байрлалын судалгаа*. Хэл шинжлэлийн докторын зэрэг горилсон бүтээл. МУИС.
- Гэрэлмаа Г.** 2012. *Хэрэглээний хэл шинжлэл*. Уб.,
- Гэрэлмаа Г.** 2015. *Монгол хэл мөхөж байгаа юу?*. Эх хэлний ирээдүй судлалд. х.15-20. Зиндаа.мн. 2019.4.3. “Монголын фэйсбүүк хэрэглэгчдийн тоо 2,2 саяд хүрч Азид тэргүүлжээ”. <https://news.zindaa.mn/2oew>
- Монгол хэлний журамласан толь. <http://toli.gov.mn/>
- Монголын Хэвлэлийн хүрээлэн. 2013. *Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мониторингийн судалгаа*. Улаанбаатар.
- Мөнх-Учрал Э.** 2005. *Монгол, кирилл бичгийг харилцан хөрвүүлэх програмд зориулсан хэлзүйн толь бичгийг боловсруулах судалгаа*. Эх бичиг судлалын магистрын зэрэг горилсон зохиол. МУИС.
- Мөнх-Учрал Э.** 2010. *Хөрвүүлэх програмд зориулсан монгол хэлний судалгаа*. Хэл шинжлэлийн докторын зэрэг горилсон зохиол. МУИС.
- Мөнхчимэг Д., Чимэддондог Ц.** *Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг контент анализын судалгаа*. Уб., 2018. <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14785.pdf>
- Оюундарь Н.** 2016. *Өгүүлбэрзүйн задлуур программд зориулан монгол хэлний өгүүлбэрийн бүтцийг тэмдэглэх нь*. Магистрын зэрэг горилсон бүтээл. МУИС.
- Өнөрбаян Ц.** 2013. *Монгол хэл дархлаажсан учир мөхөх аюул хол*. <https://ikon.mn/n/u2>
- Өнөрбаян Ц.** 2020. *Харь хэлний дархлаа ихсэх тусам эх хэлийг мөхөлд ойртуулдаг*. <http://peak.mn/news/tsunurbayan-khari-khelnii-darkhlaa-ikhsekh-tusam-ekh-kheliig-mukhuld-oirtuuldag>
- Пүрэвжав Э.** 1996. *Монгол хэлний хэм хэмжээ*. Уб.
- Пүрэвжав Э.** 2005. *Монгол хэл яриан дахь шинэ үг хэллэг*. Нэр томьёо судлал 7.
- Пүрэвсүрэн Т., Боролзой Д.** 2008. “Компьютер хэл шинжлэл ба цахим үгийн сан байгуулах асуудалд”. *Хэл зохиол судлал* I (33). 188-197.
- Пүрэвсүрэн Т.** 2016. *Монгол хэлний цахим хөмрөгийн байгуулалт*. Антоон Мостаэрт Монгол Судлалын төвийн семинар. <https://www.facebook.com/antoonmostaertcenter/posts/643280585829043>

- Равдан Э. 2020. *Хэрэглээний хэл шинжлэл*. Улаанбаатар: Удам соёл.
- Самбуудорж О. 2013. *Нийтийн эх хэлний боловсролын асуудалд*. Хэл зохиол судлал 6 (38). 5-13.
- Хүрэлбаатар Ү. 2013. *Цахим орчин дахь монгол хэлний илэрхийлэмж*. (Твиттерийн жишээгээр). <https://www.facebook.com/khurelbaatar.urjin/posts/260822724042537/>
- Цэнгэлмаа Б. 2018. *Цахим санд суурилсан монгол ярианы хэлний нөхцөлдүүлэн холбох нөхцөлийн давтамж хэрэглээ*. Магистрын зэрэг горилсон зохиол. МУИС.
- Чоймаа Ш. 2009. *Хэлний экологи*. Монгол судлал. XXX (318).
- Шагдарсүрэн Ц. 2007. *Эх хэлээ эвдэхгүй юм сан*. Уб., Мөнхийн үсэг. 215х.
- Шинэбаяр О., Гэрэлмаа Г., Мөнхцэцэг Н., Бат-Эрдэнэ С. 2015. *Эх хэлний ирээдүй судлал*. Уб., Соёмбо принтинг. 74х.
- Энхжаргал М. 2010. *Электрон бичвэрт тулгуурласан монгол хэлний зөв бичих зүйн судалгаа*. Магистрын зэрэг горилсон зохиол. МУИС.
- Энхжаргал М. 2019. *Орчин цагийн монгол хэлний дэд бүтээврийн бүтэц, байрлал, үүрэг*. Хэл шинжлэлийн докторын зэрэг горилсон зохиол. МУИС.
- Энхмаа Б. 2015. *Интернетийн хэл шинжлэл*. Уб.
- Энхмаа Б. 2019. *Олон нийтийн цахим сүлжээ хэрэглэгчдийн хэл хэрэглээний судалгаа*. *Хэрэглээний хэл шинжлэл*. IV(19). 171-182.
- Abbasova, Milana. 2019. *Language of Social Media: An Investigation of the changes that soft media has imposed on Language usage*. 9th International Research Conference on Education, Language and Literature. May 3-4.
- Abusa'aleek, Ao. 2015. *Internet Linguistics: A Linguistic analysis of Electronic discourse as a new variety of language*. International Journal of English Linguistics 5(1). 135-145.
- Crystal, David. 2011. *Language and the Internet*. Routledge.
- Herdagdelen, Amaz., Marco Marelli. 2017. *Social Media and Language Processing: How Facebook and Twitter provide the best Frequency Estimates for Studying Word Recognition*. Cognitive Science May 41(4): 976-995.
- Huda, Salaah Rashid. 2020. *The Arabic Language in Social Medias' era*. Utopia Praxis Latinoamericana. 356-366.
- Jongbloed-Faber, Lysbeth., Hans Van de Velde., Cor van der Meer i Edwin Klikenberg. 2016. *Language use of Frisian bilingual teenagers on social media*. Treballs de Sociolingüística Catalana. 26. 27-54.
- Lantz-Andersson, Annika. 2017. *Language play in a second language: Social media as contexts for emerging Sociopragmatic competence*.
- Stæhr, Andreas. 2014. *Social media and everyday language use among Copenhagen youth*. København: Det Humanistiske Fakultet, Københavns Universitet.
- Zhuravleva, Anastasia. 2016. *Using social media to measure language use*. Journal of Multilingual and Multicultural Development. Vol.37. 601-614.

Цахим орчин дахь бодит өгөгдөлд буй үгсээс жишээлбэл,

Д/д	Үг	Давтамж	Өгөгдлийн ангилал	Агуулга
	жанхуу	47	Этгээд	Женко
	мояа	29	Этгээд	Монгол ялна
	яшка	28	Этгээд	Янхан
	миа	24	Этгээд	Муу
	лаларууд	10	Этгээд	Лалар
	лаларын	11	Этгээд	Лалар
	биобанк	26	Шинэ үг	Био банк
	изасгийн	25	Шинэ үг	И-засаг
	мавгай	1	Үг давтаж бүтсэн	Авгай +
	маниад	1	Үг давтаж бүтсэн	Ханиад +
	мархиа	1	Үг давтаж бүтсэн	Тархи +
	мохиолоо	1	Үг давтаж бүтсэн	Зохиол +
	халигуун	43	Монгол бичгийн галиг	Халиун
	хүмүн	20	Монгол бичгийн галиг	Хүн
	агула	11	Монгол бичгийн галиг	Уул
	чихинү	11	Монгол бичгийн галиг	чихний
	УИХ	15986	Товчилсон үг	
	ОХУ	10690	Товчилсон үг	
	ХХК	9136	Товчилсон үг	
	БНХАУ	6068	Товчилсон үг	
	МУИС	849	Товчилсон үг	
	бсан	915	Товчилсон үг	Байсан
	шд	720	Товчилсон үг	Шүү дээ
	шдээ	673	Товчилсон үг	Шүү дээ
	шдэ	105	Товчилсон үг	Шүү дээ
	шт	92	Товчилсон үг	Шүү дээ
	нхн	100	Аялга	
	ааа	46	Аялга	
	зассс	7	аялга	

Цахим орчны бодит өгөгдөлд буй “монгол” гэсэн үг бүхий алдаатай бичлэг

Д/Д	Нэгж	Давтамж	Шинжилгээ	Шалтгаан
1	ангитмонгол	1594	алдаатай	нийлүүлсэн
2	армонгол	7	алдаатай	нийлүүлсэн
3	армонголыг	2	алдаатай	нийлүүлсэн
4	ашигтаймонгол	25	алдаатай	нийлүүлсэн
5	аюултаймонгол	29	алдаатай	нийлүүлсэн
6	багтанаөвөрмонголд	1	алдаатай	нийлүүлсэн
7	байлаамонгол	43	алдаатай	нийлүүлсэн
8	байнамонгол	47	алдаатай	нийлүүлсэн

9	байгальдээлтэймонгол	1	алдаатай	нийлүүлсэн
10	бидмонголоороо	1	алдаатай	нийлүүлсэн
11	болономонгол	25	алдаатай	нийлүүлсэн
12	босоомонголбичиг	25	алдаатай	нийлүүлсэн
13	бүтээлчмонгол	1	алдаатай	нийлүүлсэн
14	бүхмонголчуудатүгээ	1	алдаатай	нийлүүлсэн
15	гадаададгацсанмонголчууд	1	алдаатай	нийлүүлсэн
16	гаргалаамонгол	74	алдаатай	нийлүүлсэн
17	гүрэнтмонгол	2	алдаатай	нийлүүлсэн
18	ёстоймонгол	25	алдаатай	нийлүүлсэн
19	зүймонголын	26	алдаатай	нийлүүлсэн
20	илгээхмонгол	1	алдаатай	нийлүүлсэн
21	илүүмонгол	1	алдаатай	нийлүүлсэн
23	монголардийн	1	алдаатай	нийлүүлсэн
24	монголардынзүйрүгс	1	алдаатай	нийлүүлсэн
25	монголардыннам	2	алдаатай	нийлүүлсэн
26	монголбанг	3	алдаатай	нийлүүлсэн
27	монголбанк	3428	алдаатай	нийлүүлсэн
28	монголбанкаар	3	алдаатай	нийлүүлсэн
29	монголбанканд	29	алдаатай	нийлүүлсэн
30	монголбанкийг	13	алдаатай	нийлүүлсэн
31	монголбанкинд	15	алдаатай	нийлүүлсэн
32	монголбанкнаас	182	алдаатай	нийлүүлсэн
33	монголбанкны	545	алдаатай	нийлүүлсэн
34	монголбанкных	11	алдаатай	нийлүүлсэн
35	монголбанкныханд	3	алдаатай	нийлүүлсэн
36	монголбанктай	24	алдаатай	нийлүүлсэн
37	монголбанктайгаа	1	алдаатай	нийлүүлсэн
39	монголбичиг	12	алдаатай	нийлүүлсэн
40	монголбөхийнбарилдаан	2	алдаатай	нийлүүлсэн
41	монголдагуур	2	алдаатай	нийлүүлсэн
42	монголдитөрийн	1	алдаатай	нийлүүлсэн
43	монголдоол	1	алдаатай	нийлүүлсэн
44	монголдох	1	алдаатай	нийлүүлсэн
45	монголдүйлдвэрлэв	4	алдаатай	нийлүүлсэн
46	монголжиргээ	1	алдаатай	нийлүүлсэн
47	монголзөгийнбал	1	алдаатай	нийлүүлсэн
48	монголкхүн	1	алдаатай	нийлүүлсэн
49	монголлавлах	12	алдаатай	нийлүүлсэн
50	монголмөрөөдөл	1	алдаатай	нийлүүлсэн
51	монголмэдээ	85	алдаатай	нийлүүлсэн
52	монголнефть	1	алдаатай	нийлүүлсэн
53	монголохиноос	1	алдаатай	нийлүүлсэн
54	монголпарадокс	2	алдаатай	нийлүүлсэн

55	монголруу	24	алдаатай	нийлүүлсэн
56	монголруугаа	3	алдаатай	нийлүүлсэн
57	монголулс	2	алдаатай	нийлүүлсэн
58	монголулсманданбадраг	2	алдаатай	нийлүүлсэн
59	монголулсын	4	алдаатай	нийлүүлсэн
60	монголхүн	1	алдаатай	нийлүүлсэн
61	монголхүнийтөлөө	3	алдаатай	нийлүүлсэн
62	монголхэл	3	алдаатай	нийлүүлсэн
63	монголхэлбичгийг	1	алдаатай	нийлүүлсэн
64	монголчуудаамуулдаг	1	алдаатай	нийлүүлсэн
65	монголчуудыгүздэггүй	1	алдаатай	нийлүүлсэн
66	монголымэдээ	1	алдаатай	нийлүүлсэн
67	монголынбизнес	1	алдаатай	нийлүүлсэн
68	монголынзалуучуудын	2	алдаатай	нийлүүлсэн
69	монголыннихун	1	алдаатай	нийлүүлсэн
70	монголынмэдээ	23	алдаатай	нийлүүлсэн
71	монголыннууцтовчоо	1	алдаатай	нийлүүлсэн
72	монголынталбай	1	алдаатай	нийлүүлсэн
73	монголынтөлөөхзүрхбүхэнд	1	алдаатай	нийлүүлсэн
74	монголынхүнсчдийнхолбоо	3	алдаатай	нийлүүлсэн
75	монголэрчүүдээхайрлая	1	алдаатай	нийлүүлсэн
76	монголэхнэръялна	1	алдаатай	нийлүүлсэн
77	монголялна	1	алдаатай	нийлүүлсэн
78	монголялсан	1	алдаатай	нийлүүлсэн
79	мэдээмонгол	16	алдаатай	нийлүүлсэн
80	мэдээмонголбанк	4	алдаатай	нийлүүлсэн
81	мэдээмонголбанкны	4	алдаатай	нийлүүлсэн
82	мэдээмонголчууд	24	алдаатай	нийлүүлсэн
83	мэдээмонголчуудын	58	алдаатай	нийлүүлсэн
84	мэдээмонголын	9	алдаатай	нийлүүлсэн
85	мэдээөвөрмонголд	145	алдаатай	нийлүүлсэн
86	ойрадмонгол	2	алдаатай	нийлүүлсэн
87	оронмонгол	1	алдаатай	нийлүүлсэн
88	суралцаараймонголын	11	алдаатай	нийлүүлсэн
89	сэтгэдэгмонгол	3	алдаатай	нийлүүлсэн
90	үедмонгол	2	алдаатай	нийлүүлсэн
91	үнэтэймонголын	11	алдаатай	нийлүүлсэн
92	хаалаамонголчууд	10	алдаатай	нийлүүлсэн
93	хуульгүймонгол	1	алдаатай	нийлүүлсэн
94	ягмонгол	1	алдаатай	нийлүүлсэн
95	ялагчмонгол	20	алдаатай	нийлүүлсэн
96	Нийслэлийнмонголардын намынхороо	4	алдаатай	нийлүүлсэн
97	болмонгол	1	алдаатай	нийлүүлсэн

98	евермонгол	1	алдаатай	гар
99	евермонголын	1	алдаатай	Гар
100	монгол	12	алдаатай	Дүрэм, шивэх
101	монглоос	2	алдаатай	Дүрэм, шивэх
102	монглын	18	алдаатай	Дүрэм, шивэх
103	монгод	6	алдаатай	Дүрэм, шивэх
104	монгодоо	2	алдаатай	Дүрэм, шивэх
105	монгодын	2	алдаатай	Дүрэм, шивэх
106	монголийг	6	алдаатай	Дүрэм, шивэх
107	монголийн	7	алдаатай	Дүрэм, шивэх
108	монголо	3	алдаатай	Дүрэм, шивэх
109	монголооос	2	алдаатай	Дүрэм, шивэх
110	монголооро	2	алдаатай	Дүрэм, шивэх
111	монголоороол	2	алдаатай	Дүрэм, шивэх
112	монголор	2	алдаатай	Дүрэм, шивэх
113	монголс	4	алдаатай	Дүрэм, шивэх
114	монголт	17	алдаатай	Дүрэм, шивэх
115	монголтойгооо	2	алдаатай	Дүрэм, шивэх
116	монголууд	4	алдаатай	Дүрэм, шивэх
117	монголы	9	алдаатай	Дүрэм, шивэх
118	монголыгн	2	алдаатай	Дүрэм, шивэх
119	монголых	4	алдаатай	Дүрэм, шивэх
120	монгочуудын	2	алдаатай	Дүрэм, шивэх
121	монгоын	3	алдаатай	Дүрэм, шивэх
122	монголжингоос	3	алдаатай	Дүрэм, шивэх
123	монголилсон	2	алдаатай	Дүрэм, шивэх
124	монголнч	1	алдаатай	Дүрэм, шивэх
125	монголчилвол	1	алдаатай	Дүрэм, шивэх
126	монголчилоод	1	алдаатай	Дүрэм, шивэх
127	монголчихож	1	алдаатай	Дүрэм, шивэх
128	монголчуудынхаа	2	алдаатай	Дүрэм, шивэх
129	монголчуудынхаа	10	алдаатай	Дүрэм, шивэх
130	монглчууд	2	алдаатай	Дүрэм, шивэх
131	монголчу	6	алдаатай	Дүрэм, шивэх
132	монголчуу	6	алдаатай	Дүрэм, шивэх
133	монголчуудадаа	2	алдаатай	Дүрэм, шивэх
134	монголчуудийг	2	алдаатай	Дүрэм, шивэх
135	монголчуудийн	5	алдаатай	Дүрэм, шивэх
136	монголчуудных	2	алдаатай	Дүрэм, шивэх
137	монголчууды	3	алдаатай	Дүрэм, шивэх
138	монголчууныг	2	алдаатай	Дүрэм, шивэх
139	монголчуууд	3	алдаатай	Дүрэм, шивэх
140	онголчууд	3	алдаатай	Дүрэм, шивэх
141	нгол	4	алдаатай	Дүрэм, шивэх

142	нголоос	8	алдаатай	Дүрэм, шивэх
143	онголын	10	алдаатай	Дүрэм, шивэх
144	онголбанк	1	алдаатай	Дүрэм, шивэх
145	нголын	1	алдаатай	Дүрэм, шивэх

Хавсралт 3

**Цахим орчны бодит өгөгдлийн хүрээнд тохиолдож буй
7,000-аас дээш давтамжтай, зөв бичлэгтэй 247 нэгжийн жагсаалт**

	Нэгж	Давтамж		
1	нь	173230	36	нэр
2	Монгол	120833	37	эрх
3	байна	114122	39	байдаг
4	юм	71322	40	дээр
5	энэ	67982	41	засгийн
6	байгаа	66962	42	цагийн
7	ч	65334	43	бид
8	гэж	58151	44	газар
9	улсын	53792	45	тухай
10	л	52106	46	болно
11	хүн	43643	47	буй
12	ын	42147	48	вэ
13	бол	41087	49	хариулах
14	олон	40055	50	орон
15	их	37972	51	жил
16	улс	36698	52	кино
17	нэг	35618	53	болсон
18	өмнө	35185	54	манай
19	сэтгэгдэл	35042	55	тэр
20	байсан	34382	56	ямар
21	аниме	33541	57	газрын
23	болон	28854	58	монголд
24	монголын	28546	59	дарга
25	та	27180	60	хувь
26	үү	26449	61	хоёр
27	хүний	26063	62	сайд
28	уу	25421	63	өдөр
29	сарын	25234	64	хамгийн
30	бүх	24874	65	гэдэг
31	бичих	24608	66	дэд
32	гэсэн	24499	67	мөн
33	оны	24407	68	онд
34	байх	23822	69	эх
35	төрийн	22139	70	болж
			71	УИХ

72	албан	15950
73	мэдээлэл	15760
74	эдийн	15674
75	нар	15552
76	би	15463
77	болох	15423
78	биш	15422
79	ерөнхийлөгч	15361
80	гээд	15280
81	цаг	15221
82	хийж	15179
83	тус	15167
84	авч	15140
85	жилийн	14564
86	үйл	14458
87	талаар	14416
88	халуун	14280
89	үед	14054
90	бус	13937
91	сая	13864
92	засаг	13675
93	харин	13557
94	ерөнхий	13464
95	эрүүл	13459
96	байж	13270
97	нийгэм	13254
98	шинэ	13073
99	ёстой	13024
100	төр	12932
101	маш	12895
102	сайн	12740
103	ажиллаж	12532
104	санал	12393
105	хэрэгтэй	12317
106	үг	12304
107	чөлөөт	12290
108	бөгөөд	12214
109	ажил	12049
110	бий	11962
111	сэдвүүд	11893
112	бизнес	11869
113	юу	11797
114	хуулийн	11792
115	Баттулга	11786

116	авах	11643
117	ард	11604
118	буюу	11603
119	өөрийн	11597
120	холбоотой	11496
121	сайхан	11476
122	хууль	11351
123	хүүхэд	11323
124	улсад	11280
125	одоо	11218
126	хүмүүс	11208
127	монголчууд	11200
128	гэх	11133
129	гэр	11113
130	хоногийн	11092
131	аймгийн	10863
132	шиг	10823
133	хуулиар	10806
134	аж	10751
135	ийм	10728
136	ОХУ	10690
137	дэлхийн	10653
138	нүүрс	10620
139	үр	10616
140	дахь	10486
141	хувьд	10444
142	хэл	10422
143	арга	10392
144	үндэсний	10332
145	МАН	10289
146	руу	10285
147	ирсэн	10272
148	дугаар	10139
149	бусад	10125
150	дараа	10057
151	гадаад	10032
152	мэдээ	9994
153	бүр	9921
154	дэлхий	9908
155	зохион	9893
156	бичнэ	9888
157	боловсрол	9877
158	нийтэлсэн	9689
159	таны	9646

160	хамгаалагдсан	9559
161	хийх	9522
162	өндөр	9408
163	бас	9316
164	нутгийн	9288
165	асуудал	9279
166	ёс	9255
167	ажлын	9234
168	ххк	9136
166	том	9095
170	нийт	8995
172	зэрэг	8954
172	иргэн	8932
173	хүртэл	8893
174	хятад	8853
175	түүх	8817
176	нийслэлийн	8782
177	орж	8765
178	төв	8715
179	боломжтой	8626
180	болоод	8596
181	иргэд	8580
182	гишүүн	8574
183	УЛААНБААТАР	8503
184	зэрэг	8954
185	иргэн	8932
186	хүртэл	8893
187	хятад	8853
188	түүх	8817
189	нийслэлийн	8782
190	орж	8765
191	төв	8715
192	боломжтой	8626
193	болоод	8596
194	иргэд	8580
195	гишүүн	8574
196	улаанбаатар	8503
197	билээ	8431
198	чинь	8422
199	зүйл	8420
200	маань	8420
201	авсан	8327
202	амьдрал	8224
203	түр	8155

204	бага	8149
205	хэмээн	8091
206	үнэ	8045
207	уг	8013
208	Хүрэлсүх	8005
209	иргэдийн	7996
210	зүйл	8420
211	нийгмийн	7957
212	компани	7947
213	хөгжил	7936
214	илүү	7858
215	өөр	7826
216	даа	7765
217	хэдэн	7755
218	хүнд	7704
219	хийсэн	7689
220	гаруй	7679
221	багш	7605
222	технолог	7593
223	тухайн	7536
224	хүүхдийн	7515
225	байхгүй	7500
226	мэнд	7499
227	хугацаанд	7481
228	дахин	7441
229	тэрбум	7429
230	бүрэн	7424
231	миний	7414
232	өдрийн	7393
233	цахим	7370
234	эрдэнэ	7334
235	төсвийн	7333
236	хөрөнгө	7323
237	төгрөг	7314
238	болгох	7287
239	хэрэг	7286
240	гол	7240
241	мэндийн	7224
242	нүүр	7217
243	гурван	7163
244	мөнгө	7085
245	удаа	7066
246	сургууль	7008
247	хувийн	7008